

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/063/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025.02.13	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат	
	Утас: 99007576	Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
	Аудитын менежер: М.Алтантуяа	
	Утас: 99061829	Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
	Аудитор: Г.Энхзул	
Утас: 99333147	Цахим хаяг: enkhzulg@audit.gov.mn	
	Цахим хуудас: www.audit.mn	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2025.02.17 № 2/16

танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын илэрсэн алдаа, зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 111 арга

5020160

хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 94.6% хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	79,368,355.26	70,715,492.97
33	АВЛАГА	33,944,990.84	54,331,525.97
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	48,300.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	33,896,690.84	54,331,525.97
35	БАРАА МАТЕРИАЛ	45,423,364.42	16,383,967.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	55,346.00	55,346.00
354	Хангамжийн материал	45,368,018.42	16,328,621.00
35410	Бичиг хэргийн материал	1,380,500.00	448,050.00
35420	Аж ахуйн материал	1,694,500.00	2,664,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	16,245,000.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	87.42	00.00
35470	Бусад хангамжийн материал	26,047,931.00	13,216,071.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	492,464,671.25	438,282,311.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	492,464,671.25	438,282,311.45
392	Биет хөрөнгө	404,379,838.02	349,011,478.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	195,394,386.72	195,394,386.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	-23,504,778.40	-27,645,733.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	172,700,000.00	172,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-102,952,777.82	-127,569,444.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	335,780,836.56	368,166,971.94
39206	Хуримтлагдсан элэгдэл	-190,524,720.49	-251,078,891.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,975,776.12	39,669,976.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,488,884.67	-20,625,786.87
393	Биет бус хөрөнгө	88,084,833.23	89,270,833.19
39301	Программ хангамж	1,030,000.00	2,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-706,166.77	-840,166.81
39303	Бусад биет бус хөрөнгө	87,761,000.00	87,761,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	571,833,026.51	508,997,804.42
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	571,833,026.51	508,997,804.42
51	Засгийн газрын хувь оролцоо	571,833,026.51	508,997,804.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	386,538,027.70	386,538,027.70
51101	Өмч: - төрийн	386,538,027.70	386,538,027.70
512	Хуримтлагдсан үр дүн	123,464,674.44	60,629,452.35
51210	Өмнөх үеийн үр дүн	172,253,146.70	172,253,146.70
51220	Тайлант үеийн үр дүн	-48,788,472.26	-111,623,694.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	61,830,324.37	61,830,324.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	571,833,026.51	508,997,804.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,143,901,799.88	1,620,058,147.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	130,397,669.88	174,210,351.51
120	Нийтлэг татварын бус орлого	130,397,669.88	174,210,351.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	128,913,690.84	170,724,216.13
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	128,913,690.84	170,724,216.13
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,013,504,130.00	1,445,847,796.10
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	994,586,800.00	1,389,361,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	994,586,800.00	1,389,361,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,037,850.00	53,528,678.45
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	31,346,137.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,037,850.00	21,182,541.00
1330	Төсвийн захирагчдаас	4,879,480.00	2,957,217.65
133003	Хөрөнгийн	4,879,480.00	2,957,217.65
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,192,690,272.14	1,682,893,369.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,192,690,272.14	1,682,893,369.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,120,759,690.58	1,514,330,453.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	787,742,317.67	1,077,970,614.17
210101	Үндсэн цалин	507,579,077.60	601,573,206.71
210102	Нэмэгдэл	205,736,356.30	364,547,645.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,355,000.00	49,292,027.74
210104	Урамшуулал	29,071,883.77	62,557,734.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,138,776.37	142,706,628.94
210201	Тэтгэврийн даатгал	66,583,168.00	100,679,593.72
210202	Тэтгэмжийн даатгал	7,796,318.56	10,506,758.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,403,705.20	5,253,379.40
210204	Ажилгүйдлийн даатгал	1,577,780.42	5,253,379.40
210205	Эрүүл мэндийн даатгал	15,777,804.19	21,013,517.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,001,268.86	26,021,219.10
210301	Гэрэл, цахилгаан	2,745,160.86	2,494,245.10
210302	Түлш, халаалт	20,501,100.00	20,378,074.00
210303	Цэвэр, бохир ус	2,755,008.00	3,148,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,502,580.00	21,111,246.07
210401	Бичиг хэрэг	4,295,480.00	7,476,307.25
210402	Тээвэр, шатахуун	3,481,000.00	12,909,860.42
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	280,400.00	275,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	445,700.00	449,978.40
2105	Нормативт зардал	168,200.00	00.00

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	168,200.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	2,859,900.00	2,688,300.00
210702	Дотоод албан томилолт	2,859,900.00	2,688,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,515,192.00	9,024,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,306,492.00	8,851,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	35,400.00	34,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,000.00	94,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,300.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	188,831,455.68	234,808,245.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,628,513.54	141,225,549.90
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	105,202,942.14	93,582,695.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,930,581.56	166,528,916.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	911,760.00	109,774,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	911,760.00	2,697,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	99,637,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	7,440,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	71,018,821.56	56,788,516.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	64,874,971.56	56,685,176.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(48,788,472.26)	(62,835,222.09)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,103,641,650.00	1,593,179,959.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	95,017,000.00	150,289,381.00
120	Нийтлэг татварын бус орлого	95,017,000.00	150,289,381.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	95,017,000.00	150,289,381.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	95,017,000.00	150,289,381.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,008,624,650.00	1,442,890,578.45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	994,586,800.00	1,389,361,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	994,586,800.00	1,389,361,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,037,850.00	53,528,678.45
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	31,346,137.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,037,850.00	21,182,541.00

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,101,272,950.00	1,557,265,759.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,101,272,950.00	1,557,265,759.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,029,342,368.44	1,388,702,843.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	787,742,317.67	1,086,471,268.64
210101	Үндсэн цалин	507,579,077.60	557,607,023.01
210102	Нэмэгдэл	205,736,356.30	417,014,483.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,355,000.00	49,292,027.74
210104	Урамшуулал	29,071,883.77	62,557,734.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,138,776.37	134,157,674.47
210201	Тэтгэврийн даатгал	66,583,168.00	92,130,639.25
210202	Тэтгэмжийн даатгал	7,796,318.56	10,506,758.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,403,705.20	5,253,379.40
210204	Ажилгүйдлийн даатгал	1,577,780.42	5,253,379.40
210205	Эрүүл мэндийн даатгал	15,777,804.19	21,013,517.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,001,268.86	25,808,600.00
210301	Гэрэл, цахилгаан	2,745,160.86	2,281,626.00
210302	Түлш, халаалт	20,501,100.00	20,378,074.00
210303	Цэвэр, бохир ус	2,755,008.00	3,148,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,147,700.00	6,372,800.00
210401	Бичиг хэрэг	940,600.00	2,080,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,481,000.00	3,414,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	280,400.00	275,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	445,700.00	602,200.00
2105	Нормативт зардал	168,200.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	168,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	900,000.00
210604	Урсгал засвар	-	900,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,923,900.00	2,868,300.00
210702	Дотоод албан томилолт	2,923,900.00	2,868,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,604,700.00	9,024,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,396,000.00	8,851,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	35,400.00	34,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,000.00	94,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,300.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,615,505.54	123,100,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,615,505.54	123,100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,930,581.56	166,528,916.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	911,760.00	109,774,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	911,760.00	2,697,200.00

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	99,637,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	7,440,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	71,018,821.56	56,685,176.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	64,874,971.56	56,685,176.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,368,700.00	35,914,200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,368,700.00	35,914,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,368,700.00	35,914,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,368,700.00	35,914,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,368,700.00	35,914,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,368,700.00)	(35,914,200.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/	
					Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	328,802,027.70	61,894,119.75	209,518,515.62	-	600,214,663.07
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	328,802,027.70	61,894,119.75	209,518,515.62	-	600,214,663.07
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	19,587,571.80	-	19,587,571.80
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	386,538,027.70	61,830,324.37	123,464,674.44	-	571,833,026.51
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	386,538,027.70	61,830,324.37	123,464,674.44	-	571,833,026.51
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	386,538,027.70	61,830,324.37	123,464,674.44	-	571,833,026.51
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(62,835,222.09)	-	(62,835,222.09)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	386,538,027.70	61,830,324.37	60,629,452.35	-	508,997,804.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,539,361,900.00	1,482,676,723.96	56,685,176.04	96.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,539,361,900.00	1,482,676,723.96	56,685,176.04	96.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,437,027,500.00	1,380,342,323.96	56,685,176.04	96.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,104,803,600.00	1,057,865,819.92	46,937,780.08	95.75
210101	Үндсэн цалин	584,248,600.00	535,342,599.63	48,906,000.37	91.63
210102	Нэмэгдэл	450,089,200.00	410,673,458.05	39,415,741.95	91.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,912,700.00	49,292,027.74	-19,379,327.74	164.79
210104	Урамшуулал	40,553,100.00	62,557,734.50	-22,004,634.50	154.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,843,200.00	131,416,985.04	9,426,214.96	93.31
210201	Тэтгэврийн даатгал	95,773,400.00	89,389,949.82	6,383,450.18	93.33
210202	Тэтгэмжийн даатгал	11,267,500.00	10,506,758.80	760,741.20	93.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,633,700.00	5,253,379.40	380,320.60	93.25
210204	Ажилгүйдлийн даатгал	5,633,700.00	5,253,379.40	380,320.60	93.25
210205	Эрүүл мэндийн даатгал	22,534,900.00	21,013,517.62	1,521,382.38	93.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,808,600.00	25,553,219.00	255,381.00	99.01
210301	Гэрэл, цахилгаан	2,548,100.00	2,281,626.00	266,474.00	89.54
210302	Түлш, халаалт	20,111,600.00	20,122,693.00	-11,093.00	100.06
210303	Цэвэр, бохир ус	3,148,900.00	3,148,900.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,217,800.00	5,217,800.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	925,600.00	925,600.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	3,414,900.00	3,414,900.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,100.00	275,100.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	602,200.00	602,200.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	2,868,300.00	2,868,300.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	2,868,300.00	2,868,300.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,056,000.00	8,024,200.00	31,800.00	99.61
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,851,300.00	7,851,300.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	34,700.00	34,700.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	94,200.00	94,200.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,800.00	44,000.00	31,800.00	58.05

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	149,430,000.00	149,430,000.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	149,430,000.00	149,430,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,334,400.00	102,334,400.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	102,334,400.00	102,334,400.00	0.00	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,697,200.00	2,697,200.00	0.00	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	99,637,200.00	99,637,200.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,539,361,900.00	1,482,676,723.96	56,685,176.04	96.32
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,389,361,900.00	1,332,676,723.96	56,685,176.04	95.92
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,389,361,900.00	1,332,676,723.96	56,685,176.04	95.92
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	150,000,000.00	150,000,000.00	0.00	100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000,000.00	150,000,000.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	42.00	34.00	8.00	80.95
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	28.00	8.00	77.78
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,837,850.00	53,528,678.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,837,850.00	53,528,678.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,894,000.00	43,985,338.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		28,605,448.72
210101	Үндсэн цалин		22,264,423.38
210102	Нэмэгдэл		6,341,025.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,740,689.43
210201	Тэтгэврийн даатгал		2,740,689.43
2104	Хангамж, бараа материалын зардал		1,155,000.00
210401	Бичиг хэрэг		1,155,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		10,484,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		7,750,000.00
210602	Тавилга		1,834,200.00
210604	Урсгал засвар		900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,894,000.00	1,000,000.00

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,894,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	7,440,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		7,440,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		7,440,000.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		2,103,340.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,837,850.00	53,528,678.45
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,837,850.00	53,528,678.45
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		31,346,137.45
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,837,850.00	23,182,541.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь эрхэм зорилгоо "Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь Иргэдэд газар, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн болон газрын кадастрын талаарх төрөөс үзүүлэх үйлчилгээг ил тод, шударга, хөнгөн шуурхай үзүүлж, тэдний эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино" гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газар хэрэгжүүлдэг ба дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/157 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.3-д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 508,997.8 мянган төгрөг болж өмнөх оноос 62,835.23 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	ДҮН	ЭЗЛЭХ ХУВЬ	ДҮН	ЭЗЛЭХ ХУВЬ	ДҮН	ЭЗЛЭХ ХУВЬ
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	79,368.36	13.88	70,715.49	13.89	(8,652.87)	13.77
МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00	00.00	00.00	-	-
АВЛАГА	33,944.99	05.94	54,331.53	10.67	20,386.54	(32.44)
УРЬДЧИЛГАА	00.00	00.00	00.00	00.00	-	-
БАРАА МАТЕРИАЛ	45,423.44	79.43	16,383.97	03.22	(29,039.47)	46.22
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	492,464.67	86.12	438,282.31	86.11	(54,182.36)	86.23
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	492,464.67	86.12	438,282.31	86.11	(54,182.36)	86.23
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	571,833.03	100.00	508,997.80	100.00	(62,835.23)	100.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	571,833.03	100.00	508,997.80	100.00	(62,835.23)	100.00
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	571,833.03	100.00	508,997.80	100.00	(62,835.23)	100.00

Авлагын данс эцсийн үлдэгдэл 54,331.53 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 16,383.97 мянган төгрөг болж өмнөх оноос 29,039.47 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх онд авсан авто машины сэлбэг хэрэгслийг 2024 оны 01 дүгээр сард агуулахаас зарлагадан авто машиндаа сэлбэгээ тавин энэ ондоо данснаас хассанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 438,282.31 мянган төгрөг болж 54,182.36 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд Барилга, хот байгуулалтын сайдын тушаал, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын даргын тушаал, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын албан бичиг, Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын тушаалуудаар 29,432.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,183,904.3 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж,

дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 355,713.0 мянган төгрөгөөр ихэсгэж, 1,539,361.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1,539,361.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,482,710.7 мянган төгрөгийг зарцуулж, давсан орлого 56,651.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,309,176.20	1,252,491.00	(56,685.20)	95.67
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	102,334.40	102,334.40	-	100
3	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	7,851.30	7,851.30	-	100
4	82404 Барилгын техник хяналт	120,000.00	120,000.00	-	100
Нийт		1,539,361.90	1,482,676.70	(56,685.20)	98.92

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар давсан орлого 53,528.7 мянган төгрөг орсныг багаж техник хэрэгсэл, тавилга урсгал засварт 10,484.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 1,000.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1,155.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 7,440.0 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 2,103.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 20,378.1 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 2,494.2 мянган төгрөг, Баянхонгор Хөвших Од ХХК-тай дулаанаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-иудтай цахилгаанаар хангах гэрээ тус тус байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхзул гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 179 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 1,988,496.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 19,885.0 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 13,919.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 24,240.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээний мэдээллийг дутуу мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж аудитаар 84,630.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1,052.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2024 оны 04 дугаар сарын 29-ний өдрийн 202 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,052.40	1	1,052.40	100%
Албан шаардлага	2	84,630.30	2	84,630.30	100%
Нийт дүн	3	85,682.70	3	85,682.70	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 27,224.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрч санхүүгийн тайланд залруулга хийж, 3 зөрчил илрэв. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

1. Байгууллагын ажилтан Б.Ганзоригт тайлант оны 2 болон 3 дугаар сард тус бүр 275.0 мянган төгрөг буюу нийт 550.0 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон байна.
2. Тайлант онд ХХОАТ-ын өглөг үүсээгүй байхад анхан шатны баримтгүй 400.0 мянган төгрөгийн гүйлгээ илүү хийсэн байна.
3. Аудитаар Шилэн дансны цахим хуудаст дутуу мэдээлсэн 24,240.0 мянган төгрөгийн төгрөгийн 1 зөрчил² илэрсэнд албан шаардлага өгсөн.
4. Тайлант онд тус байгууллагын харьяа байгууллага өөрчлөгдөж, данс солигдсонтой холбоотой үүссэн 2,034.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд залруулга хийв. Уг өөрчлөгдсөн дансыг хаалгах шаардлагатай.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 15,300.0 мянган төгрөгөөс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Байгууллагын ажилтан Б.Ганзоригт тайлант оны 2 болон 3 дугаар сард тус бүр 275.0 мянган төгрөг буюу нийт 550.0 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын хавсралтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох буруутай албан тушаалтнаар 550.0 мянган төгрөгийг буцаан төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

5.1.2 Санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, төсөвт батлагдаагүй ХХОАТ-ын өглөгөөр 400.0 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй гүйлгээ илүү хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 20 дугаар зүйлийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох буруутай албан тушаалтнаар 400.0 мянган төгрөгийг буцаан төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 24,240.0 мянган төгрөгийн 2 зарлагын гүйлгээг дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан 24,240.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд тус байгууллагын харьяа байгууллага өөрчлөгдөж, данс солигдсонтой холбоотой үүссэн 2,034.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд залруулга хийв.	1	2,034.0	1	2,034.0			1	2,034.0		
Дүн	1	2,034.0	1	2,034.0			1	2,023.8		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Алдааны товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын ажилтан Б.Ганзоригт тайлант оны 2 болон 3 дугаар сард тус бүр 275.0 мянган төгрөг буюу нийт 550.0 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон байна.	1	550.0	1	550.0				
Санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, төсөвт батлагдаагүй ХХОАТ-ын өглөгөөр 400.0 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй гүйлгээ илүү хийсэн байна.	1	400.0	1	400.0				
Дүн	2	950.0	2	950.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ"-д заасан 24,240.0 мянган төгрөгийн 2 зарлагын гүйлгээг дутуу мэдээлсэн.	2	24,240.0			2	24,240.0		
Дүн	2	24,240.0			2	24,240.0		

-----oO-----